

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАР

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал **2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 10:00 цагаас** тус компанийн байр (Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, МА-III барилга буюу Анкор төвийн хурлын заал)-нд хуралдах болсныг үүгээр мэдэгдэж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараахь асуудлыг шийдвэрлэнэ.

1. Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож, шинээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргад олгох сарын цалин, мөнгөн урамшууллын хэмжээг батлах;
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зардлыг компаниас гаргахыг зөвшөөрөх;

Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтад тусгасан эрх бүхий хувьцаа эзэмшигчид Төлөөлөн удирдах зөвлөл, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх саналаа 2023 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд ирүүлэхийг хүсье.

Хувьцаа эзэмшигчдийг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компани болон компанийн байрны 308 тоот өрөөнд ажлын цагаар ирж хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй танилцаж, саналаа өгөхийг хүсье.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөр** тогтоож, хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 12:00 цагаар тус тус тогтоосон болно.

Хувьцаа эзэмшигчид Та бүхнийг хуралдаа оролцохыг урьж байна.

**ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ
ЛУТАА ОВОГТОЙ БУЯНБАТ**